



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар Д/Б95

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.12, "Барилгын тухай" хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.3, 42-р зүйлийн 42.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн "Цэвэр усны эх үүсвэрийн худаг гаргах, нөөцийн сан байгуулах ажил (Хэнтий, Хэрлэн сум)" ажлын зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Оюундарь	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Х.Эрдэнэгарьд	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Ш.Ариунболор	Аймгийн ерөнхий архитектор, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн
	Б.Санчир	"Хэнтий Ус" ХХК ерөнхий инженер

2.Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ